



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/332

Номгон

Иргэн С.Анхбаярын газар эзэмших эрхийн
гэрчилгээг С.Очирхуягт, Г.Нямхүүгийн газар эзэмших
эрхийн гэрчилгээг иргэн Ө.Юмдэрмаад бусдад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмшигч иргэдийн хүсэлтийн дагуу иргэн С.Анхбаярын Баянхонгор сум, Номгон 1-р баг, Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-2, 202 тоотод байрлах 70 м2 газар эзэмших эрхийн гэрчилгээг иргэн С.Очирхуягт, Г.Нямхүүгийн Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Рашаантын гудамж-3, 348 тоотод байрлах 2069 м2 газар эзэмших эрхийн гэрчилгээг иргэн Ө.Юмдэрмаад шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхээ шилжүүлж байгаа болон шилжүүлэн авч байгаа иргэдийн үндсэн мэдээллийг хавсралтаар баталсугай.

3.Эзэмшил газрын өөрчлөлтийг цахим системд бүртгэн цахим гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

4.Эзэмшил газраа зориулалтын дагуу зүй зохистой эзэмшиж гэрээнд заасан үүргээ биелүүлж жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч иргэн С.Очирхуяг, Ө.Юмдэрмаа нарт тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т даалгасугай.

6. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны А/430 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх хэсгийн иргэн С.Анхбаяртай холбогдох хэсгийг, аймгийн Засаг даргын 2020 оны А/333 дугаар захирамжийн хавсралтын иргэн Г.Нямхүүтэй холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010919

Аймгийн Засаг даргын 2022 оны 15 дугаар сарын 29-ний өдрийн
 2/332 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР АШИГЛАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Газар эзэмших эрхээ шилжүүлж буй								Газар эзэмших эрх шилжүүлэн авч буй иргэний мэдээлэл									
№	Ургийн овог	Эцэг эхийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Нэгж талбарын хаяг	Газрын хэмжээ м2	Ургийн овог	Эцэг эхийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Газрын эрхийн төрөл	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ м2	Нэгж талбарын хаяг	Газар ашиглалтын зориулалт	Газар эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18
1	Өндөр гүнд	Сэнгээ	Анхбаяр	ВЙ83091313	6409007090	Баянхонгор сум, Номгон 1-р баг, Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-2, 202 тоот	70	Ногооныхон	Сүхбат	Очирхуяг	ВУ77010505	Эзэмших	6409007090	70	Баянхонгор сум, Номгон 1-р баг, Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-2, 202 тоот	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	7 жил
2	Эрээнийхан	Гончиг	Нямхүү	В349041506	6409000307	Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Рашаантын гудамж-3, 348 тоот	2069	Сартуул	Өлзийсайхан	Юмдэрмаа	ВЕ88041404		6409000307	2069	Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Рашаантын гудамж-3, 348 тоот	Амины орон сууц	3 жил

----oOo----

